

**ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТАСГИЙН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН СЭТГЭЛ  
ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН**

2023 оны 3 дугаар улиралд нийт 120, 4 дүгээр улиралд 85 үйлчлүүлэгч судалгаанд хамрагдсанаас 98 (52%) нь эмэгтэй, 92 (48%) нь эрэгтэй үйлчлүүлэгч хамрагдсан байна.

Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчийг тасаг, нэгжээр ангилбал ерөнхий мэс заслын тасаг, мэдрэлийн тасаг хамгийн олон үйлчлүүлэгч хамрагдсан байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1.Тасаг нэгж, үйлчлүүлэгч хамрагдсан тоо, хувь

Тасаг	III дугаар улиралд хамрагдсан хүн (n)	IV дүгээр улиралд хамрагдсан хүн (n)	Нийт хамрагдсан хүн (n)	Нийт хамрагдсан хүн %
Дотор I тасаг	20	10	30	14%
Дотор II тасаг	20	10	30	14%
Гэмтэл согог, заслын тасаг	15	15	30	14%
Ерөнхий мэс заслын тасаг	20	15	35	16%
Уламжлалт эмчилгээний тасаг	15	10	25	12%
Хүүхдийн тасаг	20	10	30	14%
Мэдрэлийн тасаг	20	15	35	16%

Үйлчлүүлэгчийг эмнэлэгт хэвтүүлэхээр анх товлосон хугацааг эмнэлгийн зүгээс эсэх өөрчилсөн эсэх гэсэн асуултанд 3 дугаар улиралд 98% нь, 4 улиралд 97% нь үгүй гэж хариулсан байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Үйлчлүүлэгчийг эмнэлэгт хэвтүүлэхээр анх товлосон хугацаа өөрчилсөн эсэх

Тасаг	Дотор I тасаг	Дотор II тасаг	Гэмтэл согог,	Ерөнхий мэс заслын тасаг	Уламжлалт эмчилгээний тасаг	Хүүхдийн тасаг	Мэдрэлийн тасаг	III дүгээр улирал (%)	IV дугаар улирал (%)
Тийм	0	0	1	0	1	0	1	2%	3%
Үгүй	30	30	29	35	24	20	34	98%	97%


Хэвтэн эмчлүүлэгчдэд эмч, ажлтанууд эмнэлгийн зохион байгуулалт, дотоод журмыг тайлбарлаж өгсөн эсэхийг судлан үзэхэд 3-р улиралд суралгаанд

хамрагсдийн 10%-д огт тайлбарлаж өгөөгүй байсан бол 4-р улиралд уг үнэлгээ 9%-иар буурч огт тайлбарлаж өгөөгүй байдал 1% болсон байна . (Хүснэгт 3.)

Хүснэгт 3. Үйлчлүүлэгчид эмнэлгийн дотоод зохион байгуулалт, дотоод журам (эмчийн үзлэгийн цаг, эргэлтийн журам, хоол тараах цаг г.м.)-ын талаар тайлбарлаж өгсөн байдал


Тасаг	I Дотор тасаг	II Дотор тасаг	Гэмтэл согог, Ерөнхий мэс заслын	Уламжлалт эмчилгээний тасаг	Хүүхдийн тасаг	Мэдрэлийн тасаг	III дүгээр улирал (%)	IV дугаар улирал (%)	
Маш сайн тайлбарлаж өгсөн	28	29	28	32	24	18	27	70%	95%
Хагас дутуу тайлбарлаж өгсөн	2	1	2	3	1	2	5	20%	4%
Огт тайлбарлаж өгөөгүй	0						2	10%	1%

Судалгаанд оролцогчдоос хэвтэн эмчлүүлж буй өрөө, тасалгааны цэвэрлэгээ, үйлчилгээний талаар судлан асуухад 3-р улиралд судалгаанд оролцогчдын 49% нь маш сайн гэж хариулж байсан бол 4-р улиралд 70% нь маш сайн гэж хариулсан байна. Харин судалгаанд оролцогчдоос өрөөний цэвэрлэгээ, үйлчилгээг маш муу гэж хариулсан хүн байсангүй (Зураг 2.)




Зураг 2. Өрөө тасалгааны цэвэрлэгээ үйлчилгээг улирлаар харьцуулбал

Хэвтүүлэн эмчлэх тасгийн эмч нарын харилцаа хандлагын талаар судлан үзэхэд судалгаанд оролцогчдын 70% нь 3 дугаар улиралд “Маш сайн” гэж хариулж байсан бол 4-р улиралд 65% нь “Маш сайн” гэж хариулсан байна. Эмч нарын харилцаа хандлагад муу үнэлгээг өгөөгүй байна. (Зураг 3)




Зураг 3. Эмч нарын харилцаа хандлага

Судалгаанд оролцогчид эмнэлгийн хоолны амт, чанарыг 3 дугаар улиралд 2% муу, 4 улиралд муу гэсэн үнэлгээ өгөөгүй боловч “Маш сайн” гэсэн үнэлгээ нь 4-р улиралд өмнөх улирлаас 18%-иар буурсан байна. (Зураг 4)




Зураг 4. Эмнэлгийн хоолны амт, чанар

Хэвтүүлэн эмчлэх тасгийн сувилагч нарын харилцаа хандлагын талаар судлан үзэхэд судалгаанд оролцогчдын 74% нь 3 дугаар улиралд маш сайн гэж хариулж байсан бол 4-р улиралд 79% нь маш сайн гэж хариулсан байна. (Зураг 5)



Зураг 5. Сувилагч нарын харилцаа, хандлагын үнэлгээ

Эмнэлгийн мэргэжилтнүүдийн өгсөн зөвлөгөө танд хэр зэрэг ойлгомжтой байсан талаар асуулгад 3 дугаар улиралд 10% ойлгомжгүй гэж хариулж байсан бол 4 дүгээр улиралд өмнөх улирлаас 9%-иар дээшилж, 19% нь ойлгомжгүй гэж хариулсан байна. (Зураг 6)



Зураг 6. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн өгсөн зөвлөгөө, зөвлөмж ойлгомжтой байсан эсэх

Хэвтэн эмчлүүлэгчдээс эмчилгээ, үйлчилгээний талаар ерөнхий сэтгэл ханамж ямар байгааг судлан үзэхэд 3 дугаар улиралд 93% нь, 4 дүгээр улиралд 95% нь “Маш сайн” гэж хариулж, үнэлгээний дүн 2 хувиар өссөн нь үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж улирал тутамд дээшилж, тусламж үйлчилгээнд сэтгэл ханамжтай байгааг илтгэж байна.

Дээрх үзүүлэлтүүдээс хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчийн хамгийн өндөр болон хамгийн бага 3 үзүүлэлтийг жагсаавал:

Хэвтүүлэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний III, IV улирлын өндөр 3 үзүүлэлт	Хэвтүүлэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний IV улиралд буурсан 3 үзүүлэлт
<ol style="list-style-type: none"> <li>1. Эмнэлгийн зохион байгуулалт, дотоод журмыг огт тайлбарлаж өгөөгүй байдал</li> <li>2. Сувилагч нарын харилцаа, хандлага</li> <li>3. Үйлчлүүлэгчийг эмнэлэгт хэвтүүлэхээр анх товлосон хугацааг эмнэлгийн зүгээс өөрчилсөн эсэх</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>1. Эмнэлгийн ажилтнуудын өгсөн зөвлөгөө танд хэр зэрэг ойлгомжтой байдал</li> <li>2. Эмнэлгийн хоолны амт, чанар</li> <li>3. Эмч нарын харилцаа хандлага.</li> </ol>

### Дүгнэлт

1. Хэвтэн эмчлүүлэх тасгуудын үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж III дугаар улиралд 93 %, IV дүгээр улиралд 95% үнэлгээтэй буюу ерөнхий сэтгэл ханамж 2%-иар дээшилсэн байна.
2. Үйлчлүүлэгчид хэвтэн эмчлүүлэх товлосон хугацаандаа эмнэлгийн тусламж үйлчилгээг авч чадаж байна.
3. Эмнэлгийн ажилтнууд хэвтэн эмчлүүлэгч нарт эмнэлгийн дотоод журам, зохион байгууллалтын талаар тайлбарлан өгч буй байдал 4-р улиралд өмнөх улирлаас 25%-иар нэмэгдсэн байна.
4. Хэвтэн эмчлүүлэгчдийн өрөө тасалгааны цэвэрлэгээ, үйлчилгээ 21%-иар сайжирсан.
5. Сувилагч нарын харилцаа, хандлага 4-р улирлыг 3-р улиралтай харьцуулахад 5%-иар сайжирсан байна.
6. Эмч нарын харилцаа хандлагыг 3 дугаар улиралд 70% нь маш сайн гэж хариулж байсан бол 4-р улиралд 65% нь маш сайн гэж хариулж, үнэлгээ 5%-иар буурсан байна.
7. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн хэвтэн эмчлүүлэгч нарт өгч буй ойлгомжтой байдлаарх зөвлөгөө, зөвлөмж өгч буй байдал 4-р улиралд өмнөх улирлаас 5%-иар буурсан байна.

-----oOo-----